

**МОНГОЛЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ИХ СУРГУУЛЬ ДАХЬ БИЕ БЯЛДАР
ХӨДӨЛГӨӨН ЗАСЛЫН МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛЫН ДЭМЖЛЭГ
ОЮУТНУУДЫН СЭРГЭЭН ЗАСАЛ - БИЕ БЯЛДАР СУДЛАЛЫН ОЙЛГОЛТЫН ТАЛААРХ
АСУУМЖ СУДАЛГАА**

Р.Наказава¹, М.Сакамото¹, О.Батгэрэл², Ч.Оюунчимэг³, Д.Цэрэндагва³
¹Эрүүл Мэндийн Шинжлэх Ухааны Салбар, Гүнма Их Сургууль, Япон улс
²Анагаах Ухааны Салбар, Гүнма Их Сургууль, Япон улс
³ЭМШУИС Эрүүл мэндийн технологийн сургууль, Монгол улс
e-mail: riena@health.gunma-u.ac.jp

Abstract

SUPPORT OF PHYSICAL THERAPY EDUCATION IN HEALTH SCIENCES UNIVERSITY OF MONGOLIA

Questionnaire Survey about the Rehabilitation and Physical Therapy for Students

*Rie Nakazawa¹, Masaaki Sakamoto¹, Batgerel Oidov², Chuluunbat Oyunchimeg³,
Dalkh Tserendagva³*

¹Graduate School of Health Sciences, Gunma University, Japan

²Graduate School of Medicine, Gunma University, Japan

³School of Health Technology, Health Sciences University of Mongolia

Purpose: To do the support of physical therapy education in Health Sciences University of Mongolia (HSUM), the attitude survey concerning rehabilitation and physical therapy was done to the students. The purpose of this study was to examine the effect and the problem in the future of support of education in Mongolia.

Method: The support of physical therapy education was begun in HSUM in July 2007, and the special lecture and practice to the specialized subjects were done in March 2009. In addition, the attitude survey concerning rehabilitation and physical therapy was done to the students in Department of Physical Therapy.

RESULTS: Curriculum of Department of Physical Therapy were 136 units, and special lectures and practices of Gunma University were nine subjects, 18 units. In the third grader and the fourth grader that attended the lectures of the specialized subjects, the understanding level concerning rehabilitation and physical therapy were high.

Conclusion: It is thought that it came to be able to do the multipronged idea because not only physical therapy but also the understanding of another occupational category increased as effect of the support of education. It is future tasks to clarify the understanding level of the contents and skills of physical therapy.

Key word: attitude survey, international exchange, support of physical therapy education

Pp.33-36, Tables 4, Figures 2, References 2

Үндэслэл.

Монгол улсын эрүүл мэндийн салбарын тогтолцоо (medical care system) нь хуучин зөвлөлт холбоот улсаас улбаатай бөгөөд бие бялдар хөдөлгөөн засалч, ахуй засалч зэрэг сэргээн засах мэргэжилтний эрх (license) байдаггүй учир ихэвчлэн сувилагч эсвэл биеийн тамирын арга зүйч нар голлож сэргээн засах эмчилгээ үйлчилгээг явуулж байна. Ийм учраас мэргэжлийн боловсон хүчинг бэлдэх нь тулгамдсан чухал асуудлын нэг болж байна.

Гүнма Их Сургууль нь сургууль хоорондын хамтын ажиллагааны гэрээг үндэс болгож, хөгжиж байгаа орнуудын их дээд сургуулиудтай хамтын ажиллагаа явуулахаас гадна мөн тухайн орныхоо боловсролын хөгжилд дэмжлэг туслалцаа үзүүлэх зорилго тавьж ажилладаг юм. Тус сургуулийн эрүүл мэндийн шинжлэх

ухааны төгсөлтийн дараах салбар нь 2007 оны 7 сард Монгол улсын Эрүүл Мэндийн Шинжлэх Ухааны Их Сургуультай (ЭМШУИС) салбар хоорондын хамтын ажиллагааны гэрээ байгуулж, бие бялдар хөдөлгөөн заслын мэргэжлийн шинэ анги нээж, улмаар хөдөлгөөн засалчдыг бэлтгэхэд боловсролын дэмжлэг туслалцаа үзүүлж ирлээ.

ЭМШУИС-д бие бялдар хөдөлгөөн засалч бэлтгэх мэргэжлийн боловсролын дэмжлэг үзүүлж байгаатай холбоотойгоор, хөдөлгөөн заслын ангид суралцаж буй оюутнуудын дунд сэргээн засал ба бие бялдар судлалын ухагдахууны талаарх ойлголтыг тодорхойлж, үзүүлж буй боловсролын дэмжлэгийн үр дүн, хойшдын тулгамдсан асуудлын талаар дүгнэлт хийх зорилго тавилаа.

Судалгааны арга зүй

2007 оноос, монгол улсад анх удаа бие бялдар хөдөлгөөн засалчын анги шинээр нээж, хөдөлгөөн засалчдыг бэлтгэхэд боловсролын дэмжлэг үзүүлээ. 2007 оны 7 сараас 2009 оны 2 сар хооронд, бие бялдар заслын талаар танилцуулга хийж, сургалтын төлөвлөгөө боловсруулахад зөвөлгөө өгч, 2009 оны 3 сараас мэргэжлийн хичээлүүдээр тусгай лекц, дадлага удирдаж явууллаа. Гүнма их сургуулиас заасан тусгай хичээлд ЭМШУИС-ийн Эрүүл мэндийн технологийн сургуулийн хөдөлгөөн засалчын ангид анхны болон хоёр дахь удаагийн элсэлтээр элссэн 3, 4-р ангийн оюутнуудыг хамарууллаа. Сэргээн засах болон бие бялдар хөдөлгөөн заслын талаарх хандлага тодорхойлох судалгаанд 2011 оны 3 сард хөдөлгөөн засалчын ангид бүртгэлтэй байсан нэгээс дөрөвдүгээр ангийн нийт 70 оюутанг хамрууллаа. Гүнма их сургуулийн тусгай хичээлд оролцсон 3, 4-р ангийн оюутнуудыг 3-4 бүлэг, хичээлд оролцоогүй 1, 2-р ангийн оюутнуудыг 1-2 бүлэг гэж тэмдэглэлээ (Хүснэгт 1). Асуумжийг 2011 оны 3 сард Гүнма их сургуулиас заасан хичээлийн төгсгөлд тарааж өгч бөглүүлэв. Асуумжийн агуулгад сэргээн засах эмчилгээ болон түүний зорилгын талаарх ойлголт, бие бялдар хөдөлгөөн заслын талаарх ойлголт, монгол улс дахь багийн эмчилгээний (team medicine) өнөөгийн байдал, хэрэгцээний талаар өөрсдөө бөглөх нэргүй асуумжийн хэлбэрээр явуулав.

Table 1. Outline of subjects

	Grade	Number (Male/ Female)	Age (mean±SD)
3rd-4th group	4 th grade	13 (0/13)	21.8±1.0 years
	3 rd grade	12 (0/12)	21.1±1.0 years
1st-2nd group	2 nd grade	26 (0/26)	20.8±1.0 years
	1 st grade	19 (1/18)	19.1±2.0 years

Үр дүн

1. Сургалтын хөтөлбөр боловсруулах ба боловсролын дэмжлэг

ЭМШУИС-ийн Эрүүл мэндийн технологийн сургуулийн хөдөлгөөн засалч мэргэжлийн сургалтын хөтөлбөрийг Гүнма их сургуулийн сургалтын хөтөлбөрийг үлгэрлэж боловсрууллаа. Ерөнхий суурь хичээлийн 37 кредит, мэргэжлийн суурь хичээлийн 45 кредит, мэргэшүүлэх хичээлийн 34 кредит, эмнэлзүйн дадлагын 20 кредит нийт 136 кредит гэж үзлээ. Анхны болон хоёр дахь элсэлтээр элссэн 3, 4-р ангийн оюутнуудад Гүнма их сургуулиас мэргэжлийн 16 кредитийн 8 хичээл, 2

кредитийн эмнэлзүйн 1 дадлагын хичээл заагдсан байна (Хүснэгт 2). Тусгай хичээлийг нийт 7 удаа хувааж эрчимжүүлсэн лекц хэлбэрээр явууллаа. Хичээлд хэрэглэх гарын авлагыг япон, англи хэлнээс монгол хэлрүү орчуулж бэлдсэн бөгөөд гарын авлага болон хичээлийн орчуулгыг Гүнма их сургуульд суралсан оюутан хариуцаж гүйцэтгэлээ.

Table 2. Specialized subjects of Gunma University (August 2011)

Subjects	Univer- sity	Date	Grade	Contents
Introduction of Physical Therapy	HSUM	2009.3	1st 2nd	Concept of rehabilitation and physical therapy, ICF classification, team medical treatment, etc
Introduction of PBL	HSUM	2009.3	1st 2nd	Outline explanation and group work of PBL
Kinesiology	HSUM	2009.9	2nd 3rd	Outline of kinesiology, each joint's kinesiology
Kinesiology	HSUM	2009.9	2nd 3rd	
Clinical Physical Therapy	HSUM	2010.3	2nd 3rd	Measurement of ROM, MMT and Sensation test
Clinical Physical Therapy	HSUM	2010.3	2nd 3rd	
Clinical Physical Therapy	HSUM	2010.9	3rd 4th	Evaluation of Pediatric and internal medicine injuries
Clinical Kinesiology	HSUM	2011.3	3rd 4th	Characteristic of kinesiology in each injuries like locomotorium, central nervous system, etc.
Practicum of Early Exposure to Clinical Physical Therapy	Gunma University	2009.12 2010.12	3rd	Visit of physical therapy in hospitals and facilities that related to Gunma University

2. Асуумж судалгааны үр дүн

1) Сэргээн заслын талаарх ойлголт (Хүснэгт 3)

3-4 бүлэгт “Нэр агуулга хоёуланг нь ойлгодог” оюутан 25 (100%), 1-2 бүлэгт “Зөвхөн нэрийг нь ойлгодог” оюутан 23 (51%) тус тус хамгийн олон байлаа.

Table 3. Understanding level of rehabilitation and physical therapy in students

	Rehabilitation		Physical Therapy	
	3rd-4th group	1st-2nd group	3rd-4th group	1st-2nd group
Understanding name and contents	25 (100%)	16 (36%)	25 (100%)	22 (49%)
Understanding only of name	0 (0%)	23 (51%)	0 (0%)	21 (47%)

2) Сэргээн заслын зорилгын талаар (олон хариулттай, Зураг 1)

3-4 бүлэгт “Бие махбодын үйл ажиллагааг нөхөн сэргээнэ” болон “Нийгмийн харилцаанд эргэн оруулна”, “Амьдралын чанар (QOL)-ыг сайжруулна” гэсэн хариултууд хамгийн олон байлаа. 1-2 бүлэгт “Эрүүл мэндийг дэмжинэ” гэсэн хариулт хамгийн олон байсан бол “Бие махбодын үйл ажиллагааг нөхөн сэргээнэ” гэсэн хариулт дараагын удаад дурдагдсан байлаа.




Figure 1. Purpose of rehabilitation

3) Бие бялдар хөдөлгөөн заслын талаар ойлголт (Хүснэгт 3)

3-4 бүлэгт “Нэр агуулга хоёуланг нь ойлгодог” оюутан 25 (100%), 1-2 бүлэгт “Нэр агуулга хоёуланг нь ойлгодог” оюутан 22 (49%), “Зөвхөн нэрийг нь ойлгодог” оюутан 21 (44%) байлаа.


4) Монгол дахь багын эмчилгээний талаар (Хүснэгт 4) 3-4 бүлэгт “Заримдаа явагддаг” 14 (56%) буюу хамгийн олон, 1-2 бүлэгт “Мэдэхгүй” 22 (49%) хамгийн олон байлаа.

Table 4. Current situation of team medical treatment in Mongolia

	3rd-4th group		1st-2nd group	
Enough	0	(0%)	1	(2%)
Part	14	(56%)	19	(42%)
None	6	(24%)	2	(4%)
Uncertainty	5	(20%)	22	(49%)
Miss of enter	0	(0%)	1	(3%)
Total	25	(100%)	45	(100%)

5) Багын эмчилгээнд шаардлагатай мэргэжилтнүүдийн талаар (Зураг 2)

3-4 бүлэгт “Хөдөлгөөн засалч” болон “Ахуй засалч” гэж хариулсан оюутан 100% буюу хамгийн олон, “Хэл, сонсгол засалч” гэж хариулсан оюутан 96% -тай байлаа. 1-2 бүлэгт “Хөдөлгөөн засалч”, “Эмч”, “Сувилагч” гэсэн хариултууд хамгийн олон байлаа. Нэр агуулга хоёуланг нь ойлгодог” оюутан 22 (49%), “Зөвхөн нэрийг нь ойлгодог” оюутан 21 (44%) байлаа. Мөн 3-4 бүлэгт “Эрүүд мэндийн нийгмийн ажилтан”, “Ортез, протез засалч” гэсэн хариултууд ч олон байлаа.



PT: Physical Therapist, OT: Occupational Therapist, ST: Speech-Language-Hearing Therapist, RT: Radiological Technologist, MSW: Medical Social Worker, PO: Prosthetist and Orthotist, Clinical Psychologist:

Figure 2. Occupational category necessary for team medical treatment

Хэлцэмж

Монгол улсад, бие бялдар хөдөлгөөн засалч болон ахуй засалч зэрэг сэргээн засах мэргэжилтний (license) байдаггүй. Үүний улмаас хэдийгээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах олон улсын гэрээт орон боловч, бодит байдал дээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих талаар төдийлөн сайн хөгжиж чадаагүй байгаа байдалтай байна. Боловсон хүчинг бэлтгэх явдал тулгамдсан асуудал болж байна. Сэргээн засах тусламжийн хувьд физик эмчилгээ, уламжлалт анагаах ухаан голлосон онцлогтой тусламж үйлчилгээ үзүүлж байгаа бөгөөд хөдөлгөөн заслын талаарх ойлголт тун хангалтгүй. Гүнма их сургуулийн эрүүл мэндийн шинжлэх ухааны төгсөлтийн дараах салбар нь ЭМШУИС-тай байгуулсан салбар хоорондын хамтын ажиллагааны гэрээнд тулгуурлаж Монгол улсад анхны бие бялдар хөдөлгөөн засалчын анги нээж, хөдөлгөөн засалч бэлтгэхэд тусламж үзүүлж ирлээ.

Сургалтын хөтөлбөрийг Япон улсын Эрүүл мэнд Хөдөлмөрийн яамнаас мөрдлөг болгож байгаа тогтоосон журамд [1] тохируулж, Гүнма их сургуулийн сургалтын хөтөлбөрийг лавалгаа болгож боловсрууллаа. Дэлхий бие бялдар заслын нийгэмлэгт (World Confederation for Physical Therapy; WCPT), ахуй заслын нийгэмлэгийн (World Federation of Occupational Therapist; WFOT) нэгэн адил бие бялдар заслын боловсролын нэгдсэн нэг хөтөлбөр байдаггүй. Гэвч WCPT-д бие бялдар хөдөлгөөн засалч бэлтгэх боловсролын тогтолцоог хамгийн багаар 4 жилийн сургалттай их дээд сургууль, мэргэжлийн боловсрол олгоход дүйцсэн боловсролын байгуулагад явуулахыг үндсэн зарчим болгож зөвлөж байгаа [2]. Япон улсын бие бялдар заслын нийгэмлэг нь WCPT-ийн гишүүн бөгөөд, сургалтын хөтөлбөр нь энэ байгуулгаар хүлээн зөвшөөрөгдсөн хөтөлбөр юм. Ийм учраас 4 жилийн боловсролын тогтолцоог бий болгож, японы сургалтын хөтөлбөртэй дүйцүүлснээр ирээдүйд WCPT-д гишүүнээр элсэн ороход боломжтой сургалтын хөтөлбөр боловсруулагдсан гэж үзэж байна.

Мөн Монгол улсад бие бялдар заслын мэргэжлийн хичээл заах бүрэлдхүүн хараахан бэлтгэгдээгүй байгаа учраас, бие бялдар хөдөлгөөн заслын ангийн 3, 4-р ангийн оюутнуудад Гүнма их сургуулийн багш нар мэргэжлийн чиглэлийн нийт 8 хичээлийг тусгай лекцийн

хэлбэрээр зааж явууллаа. Харин ийм хэлбэрээр хичээл заагаагүй 1, 2-р ангийн оюутнуудын хувьд, сэргээн засах болон бие бялдар хөдөлгөөн заслын талаарх ойлголт хангалтгүй, сэргээн засах эмчилгээний зорилгыг зөвхөн үйл ажиллагааг сэргээх явдал гэсэн ойлголт нэлээд давамгайл байсан бөгөөд өдөр тутмын үйл ажиллагаа (ADL), амьдралын чанар (QOL) гэж ойлгох явдал маш сул байгаа үр дүнг харууллаа. Мөн монгол дахь багийн эмчилгээний өнөөгийн байдлын талаар “мэдэхгүй” хариулт ихэнх байсан ба багаар үзүүлэх эмчилгээ үйлчилгээний талаар хангалтгүй ойлголттой байлаа. Улмаар багийн эмчилгээнд зайлшгүй шаардлагатай ахуй засалч, хэл сонсгол засалч, ортез протез засалч зэрэг сэргээн засах мэргэжлийн бусад мэргэжилтнүүд болон тэдгээр мэргэжилтнүүдээс бүрдэх олон талт эмчилгээний талаар нэлээд дутмаг ойлголттой байлаа. Харин, 3,4-р ангийн оюутнуудын хувьд сэргээн засах болон бие бялдар заслын талаарх ойлголтын түвшин өндөр, мөн сэргээн засахын зорилгын тухайд зөвхөн бие махбодын үйл ажиллагааны сэргээлт төдийгүй нийгмийн харилцаанд эргэн орох, өдөр тутмын үйл ажиллагаа (ADL), амьдралын чанар (QOL) гэж ойлгох явдал ч илүү байна. Улмаар, багийн эмчилгээний талаар “мэдэхгүй” гэсэн хариулагч цөөхөн, зайлшгүй шаардлагатай ахуй болон хэл сонсгол засалчаас эхлээд эрүүл мэндийн нийгмийн ажилтан, ортез протез засалч зэрэг мэргэжлүүдийг сонгосон нь өндөр хувьтай байлаа. Эндээс харахад бие бялдар заслын мэргэжлийн хичээл үзсэн 3, 4-р ангид сэргээн засах болон бие бялдар заслын ухагдахууны талаарх ойлголт сайжирч, улмаар энэ эмчилгээний зорилго, мөн чанарыг ойлгосноор бусад мэргэжлийн талаарх мэдлэг мөн өргөжиж, олон талаас бодож тунгаах чадвар сайжирсан гэж хэлэхээр байна. Хойшид, бие бялдар заслын талаар илүү сайн ойлгох, мөн бусад мэргэжил хоорондын хамаарал болоод олон талт тусламж үйлчилгээний талаарх ойлголтоо улам гүнзгийрүүлэх хэрэгцээ шаардлага их байна.

Энэ удаа сэргээн засах болон бие бялдар заслын талаарх ойлголт ямар байгааг тогтоох судалгаа байсан тул дээрх эмчилгээнүүдийн агуулга, арга брилын талаар хир зэрэг ойлголттой байгаа тухай дурдах боломжгүй юм. Гүнма их сургуулийн хувьд, ЭМШУИС-ийн хүсэлтийг харгалзан хөдөлгөөн судлал, үнэлгээ зэрэг хичээлүүдийг (Хүснэгт 2) голлон хариуцсан. Иймээс эмнэлзүйн ур чадвар, эмчлгээний талаарх агуулгыг багтаах боломж бодит байдал дээр

бэрхшээлтэй байлаа. Энэ асуудал хоёр сургуулийн хооронд хичээл хувиарлаж авах үед сайтар ярилцах ёстой асуудал байсан гэж бодогдож байна. Улмаар өнөөг хүртэл үзүүлсэн боловсролын дэмжлэгт, сургуулийн танхим дахь лекц дадлагын хичээл голлосон байсан тул эмнэлзүйн сургалт дутагдалтай байлаа. Хойшид эмнэлзүйн сэтгэлгээний үйл явц, эмнэлзүйн ур чадварыг тусгасан сургалтын дэмжлэг үзүүлэх шаардлага байгаа бөгөөд мөн оюутнуудын бие бялдар хөдөлгөөн заслын агуулга, арга барилын талаарх ойлголтыг судлаж тогтоох хэрэгцээтэй байна.

Дүгнэлт: 2011 оны 5 сард ЭМШУИС-ийг бие бялдар хөдөлгөөн засалчийн салбарын анхны төгсөлт болж, монгол улсын эрүүл мэндийн салбарт анхны бие бялдар хөдөлгөөн засалчид төрөн гарлаа. Гэвч хараахан **үндэсний хэмжээний мэргэжлийн эрх (license)** байхгүй байна. Монгол улсад бие бялдар заслыг хөгжүүлэхэд хөдөлгөөн засалчын мэргэжлийн эрхийн тогтолцоог бий болгохоос эхлээд багшлах боловсон хүчин бэлдэх, ажлын байр болоод дадлага явуулах орчин бүрдүүлэх, сурах бичиг зохиох зэрэг асуудлууд шийдэгдээгүй хэвээр байна. Хойшид ч мөн монгол улсын эрүүл мэндийн салбарын хөгжлийн төлөө, их сургууль хоорондын хамтын ажиллагааг үр дүнтэй үргэлжлүүлэх хэрэгтэй байна.

Талархал

Энэ удаагийн боловсролын туслалцааг үзүүлэхтэй холбогдож, биднийг ойлгож, дэмжлэг үзүүлж байсан Гүнма их сургуулийн Таката Күниаки ерөнхийлөгч болон тус их сургуулийн эрүүл мэндийн шинжлэх ухааны төгсөлтийн дараах салбарын сэргээн засах (бие бялдар засал судлал) мэргэжлийн тэнхимийн багш нар, профессор Сакамото-гын тэнхимийн хамт олонд талархал илэрхийлье. Мөн ЭМШУИС-ийн захирал Цэрэнхүүгийн Лхагвасүрэн болон тус сургуулийн багш нарт талархал илэрхийлье.

Ном зүй

1. e-Gov. Ministry of Internal Affairs and Communications. <http://law.e-gov.go.jp/cgi-bin/idxsearch.cgi> (only Japanese)
2. WCPT Declarations of Principle – Education. (<http://www.wcpt.org/sites/wcpt.org/files/files/WCPT-DoP-Education-Aug07.pdf>)

*Танилцаж, нийтлэх санал өгсөн:
Академич, анагаах ухааны доктор Ц.Содномпил*